

## Татвараас зайлсхийх байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ

### The Effect of Firm Characteristics on Tax Avoidance

Э. Цэцэгдэлгэр<sup>1</sup>, Б. Алтан-Эрдэнэ<sup>2</sup>, Р. Цогзолмаа<sup>3</sup>

#### Хураангуй

Бид татвараас зайлсхийх байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн тодорхойлох, тэдгээрийн нөлөөллийг тооцоолж салбар хоорондын харьцуулалт хийхийг зорьсон. Судалгааны түүвэрт 2013-2019 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан 77,515 аж ахуйн нэгжээс загварын шалгуурын дагуу 15,184 аж ахуйн нэгжийн 106,288 санхүүгийн тайлангийн мэдээлэл сонгогдож үлдсэн. Үндсэн үр дүн аж ахуйн нэгжийн хэмжээ болон мөнгөн хөрөнгө нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал буурдаг, харин хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгддэг болохыг харуулсан. Салбар хоорондын харьцуулалтын үр дүнд нийт 19 салбараас 17 салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлхийж буй байдалд дээрх хүчин зүйлүүд эерэг болон сөрөг нөлөөтэй байсан.

*Түлхүүр үгс:* татвараас зайлсхийх, татвараас зугтах, татварын үр ашигтай хувь хэмжээ

#### Abstract

We aim to determine firm characteristics and examine their effect on tax avoidance in Mongolian entities based on their financial statements information. According to the requirements of the measurement, 15,184 unique entities that are consistently operated are chosen as sample of total 77,515 entities covering the consecutive years of 2013-2019. Using panel data of 106,288 firm-year observations, we find that firm size and cash are significantly and positively related to effective tax rates, while leverage and capital intensity has a negative effect on tax avoidance. As a result of cross-sectional comparisons, these factors have both positive and negative effects on tax avoidance in 17 of the aggregate 19 sectors.

*Keywords:* tax avoidance, tax evasion, effective tax rate (ETR)

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: tsetsegdelger@num.edu.mn

<sup>2</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)  
E-mail: altanerdene.b@num.edu.mn

<sup>3</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн магистрант  
E-mail: zoloo11b@yahoo.com

## Удиртгал

Татвараас зайлсхийх байдлыг онолын хувьд татварын хувь хэмжээ, татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх магадлал, оногдуулсан шийтгэл, оноосон алданги торгууль, цаашлаад хувь хүн болон аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлага зэргээр тодорхойлдог (Allingham & Sandmo, 1972).

Олон улсад tax evasion болон tax avoidance гэсэн ойлголт судалгаанд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд дараах байдлаар ойлгож болно. Үүнд: Tax evasion гэдэг нь хувь хүн болон аж ахуйн нэгжүүд татварын хууль тогтоомжийг илт зөрчих замаар татвараас санаатайгаар зайлсхийж буй хууль бус оролдлого. Энэ нь татвар төлөгчийн хариуцлагыг бууруулахаас гадна үйл ажиллагааны бодит орлогоо багаар, зардлуудаа ихээр тайлагнах зэрэг шударга бус, төөрөгдүүлсэн тайланг ирүүлэх эсвэл татвар төлөхгүй байх асуудлыг хамааруулж үздэг. Манай улсын татварын хуулиудын дагуу энэхүү ойлголтыг татвараас зугтах гэсэн утгаар ойлгож болно. Tax avoidance гэдэг нь татварын хууль тогтоомж, гэрээ хэлцлийг илт зөрчилгүйгээр татвар ногдох орлогын хэмжээг бууруулж буй үйлдэл юм. Энд хуулийн цоорхойг ашиглах байдлыг мөн хамааруулдаг бөгөөд татварын хуулиудын дагуу татвараас зайлсхийх байдал гэж үзнэ.

Татвараас зайлсхийх (tax avoidance), татвараас зугтах (tax evasion) нь албан бус эдийн засаг үүсэх гол шалтгаан гэж судлаачид үздэг бөгөөд татвараас зайлсхийх зорилгоор бүртгэлгүй үйл ажиллагаа явуулах, татвар ногдох орлогоо нуух, хэмжээг нь бууруулах, зардлаа өсгөх замаар далд эдийн засгийн хүрээг тэлж байдаг.

Манай улсын хувьд татвараас зайлсхийх байдлын талаар хуулинд заасан дараах ойлголтууд байна. Татварын ерөнхий хуульд зааснаар:

- "татвар төлөхөөс зугтах" гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхүйг;
- "татвараас зайлсхийх" гэж татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой энэ хуулийн дараах хэсэгт заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдлийг ойлгоно гэжээ. Үүнд:

Татварын хяналт шалгалтын үеэр доор дурдсан нөхцөл бүрдсэн нь тогтоогдсон боловч хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжгүй бол Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эрхтэй байна:

- татвар төлөгч нь дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран татварын схем зохион байгуулсан;
- татварын схемийн хүрээнд тухайн татвар төлөгч татвараас зайлсхийх замаар татварын ашиг хүртсэн; гэжээ.

Цэцэгдэлгэр & Алтан-Эрдэнэ (2021) нар манай улсад үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх зорилгоор 2013-2019 оны хооронд тасралтгүй үйл ажиллагаа явуулж, татвараа төлж байсан 3,000 орчим аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн мэдээнд үндэслэн урт хугацааны татварын үр ашигтай хувь хэмжээний загварыг ашиглан үнэлгээг хийсэн байна. Тэдгээрийн судалгааны үр дүнд аж ахуйн нэгжийн хэмжээ, байршил,

бүс нутгийн ялгаанаас үл хамаарч нийт түүвэрт сонгогдсон аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь татвараас богино болон урт хугацаандаа тогтвортой зайлсхийж байна гэсэн үр дүн гарсан бөгөөд түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажлыг нээлттэй үлдээжээ. Тиймээс бид энэхүү судлагааны ажлаараа манай улсад үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг аж ахуйн нэгж, байгууллагуудын түвшинд тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг тооцоолон, салбар хоорондын харьцуулалт хийх зорилго тавьсан.

Олон улсад татвараас зайлсхийх байдлыг хэмжихдээ дээрх судлаачдын ашигласан татварын үр ашигтай хувь хэмжээний загвар буюу effective tax rate (ETR) загвар түгээмэл ашиглагддаг бөгөөд энэ нь аж ахуйн нэгжийн татварын түрэмгий байдлыг тодорхойлох боломжтой гэж үздэг байна (Chen 2010). Татвараас зайлсхийх нь хууль тогтоомж, бодлогын сул талыг ашиглан татвар төлөгчийн татварын өр төлбөрийг бууруулах оролдлого юм (Faizah & Adhivinna, 2017). Хөрөнгийн өгөөж, хөшүүрэг, аж ахуйн нэгжийн хэмжээг татвараас зайлсхийх байдалд үзүүлэх нөлөөтэй холбоотой зарим судалгаанд (Faizah & Adhivinna, 2017) нарын хийсэн ажил хамаарах бөгөөд тэдний ажлын үр дүн нь хөрөнгийн өгөөж аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдалд эерэгээр нөлөөлж байгааг харуулжээ. Харин Endah (2020) нарын Индонез улсын жишээн дээр хийсэн судлагааны үр дүнд хөрөнгийн өгөөж, хөшүүрэг болон аж ахуйн нэгжийн хэмжээ нь татвараас зайлсхийх байдалд ямар ч нөлөө үзүүлдэггүй болох нь тогтоогдсон байна.

Энэхүү судалгааны ажлын үр дүн татварын

систем болон хууль эрх зүйн орчинд зайлшгүй хийгдэх шаардлагатай бодлогын өөрчлөлтийг хийх, дээд түвшний бодлого боловсруулагчдад судалгаанд суурилсан оновчтой шийдвэр гаргахад хувь нэмэр оруулна гэж үзсэн. Бид дараагийн хэсэгт түүвэр сонголт болон судалгааны үр дүнг, гурав дах хэсэгт ажлаа нэгтгэн дүгнэхээр бэлтгэлээ.

### Судалгаа

#### *Түүвэр сонголт:*

Судалгааны түүвэрт Сангийн яамны цахим тайлангийн системд бүртгэлтэй бүх аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулахыг зорьсон боловч 2013-2019 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан 77,515 аж ахуйн нэгжүүдээс загварын шалгуурын дагуу 15,184 аж ахуйн нэгж, байгууллагын 106,288 санхүүгийн тайлангийн мэдээлэл сонгогдож үлдсэн. Мөн салбар хоорондын харьцуулалт хийхийн тулд Үндэсний статистикийн хорооноос аж ахуйн нэгж, байгууллагуудын салбараарх ангиллын мэдээллийг авсан. Уг ангилалд аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээс нь хамрааруулж 21 салбарт ангилдаг бөгөөд бидний түүвэрт сонгогдсон байгууллагууд эдгээрийн 19 салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байсан.

#### *Судалгааны загвар:*

$$GAAP ETR_{it} = \beta_0 + \beta_X X_{it} + \varepsilon_{it}$$

Үүнд: *GAAP ETR* – татварын үр ашигтай хувь хэмжээ, *X* – үл хамаарах хувьсагчид (үүнд: байгууллагын хэмжээ; хөрөнгийн өгөөж; санхүүгийн хөшүүрэг; мөнгөн хөрөнгийн эзлэх хувь; капиталжилт; үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ), *i* – тухайн аж ахуйн нэгжийг илэрхийлэх индекс, *t* – тухайн оныг илэрхийлэх

## Хүснэгт 1. Хувьсагчдын тайлбар

№	Хувьсагч	Тайлбар
1	<i>gaap_etr</i>	Татварын үр ашигтай хувь хэмжээ, тайлант оны татварын зардлыг татварын өмнөх ашигт харьцуулсан харьцаа
2	<i>size</i>	Аж ахуйн нэгжийн хэмжээ, нийт хөрөнгийн дүнгээс логарифм авсан дүн
3	<i>roa</i>	Хөрөнгийн өгөөж, татварын өмнөх ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа
4	<i>lev</i>	Санхүүгийн хөшүүрэг, урт хугацаат өр төлбөрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа
5	<i>casht</i>	Нийт хөрөнгөд мөнгөн хөрөнгийн эзлэх хувь
6	<i>capint</i>	Капиталжилт буюу нийт хөрөнгөд үндсэн хөрөнгийн эзлэх хувь
7	<i>cfot</i>	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа

индекс,  $\beta$  – регрессийн параметрууд,  $\varepsilon$  – регрессийн санамсаргүй алдаа.

Загварын хувьсагчдын тайлбарыг Хүснэгт 1-т үзүүлэв.

*Загварын хувьсагчдын тодорхойлолт:*

Аж ахуйн нэгжийн хэмжээ (*size*): Аж ахуйн нэгжийн хэмжээ нь том, бичил эсэхээс үл хамааран аж ахуйн нэгжийн ерөнхий байдлыг харуулдаг. Аж ахуйн нэгжийн хэмжээ том байх тусам аж ахуйн нэгжийн төлөв байдал сайжирна (Fahrizal, Pratomo & Kurnia 2018).

Хөрөнгийн өгөөж (*roa*): Байгууллагын удирдлагууд, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд тухайн байгууллага өөрийн хөрөнгөө хэрхэн үр ашигтай зарцуулж байгаа талаар мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл тухайн аж ахуйн нэгж, байгууллага хөрөнгийг хэрхэн ашиг болгон хувиргаж байгааг энэ үзүүлэлт харуулдаг. Тиймээс хөрөнгийн өгөөж их байх тусам тухайн аж ахуйн нэгж үр ашигтай ажиллаж байна гэж ойлгоно.

Санхүүгийн хөшүүрэг (*lev*): Санхүүгийн хөшүүргийн хэмжээ нь аж ахуйн нэгжийн капиталын бүтцийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл зээлийн эх үүсвэр ба өөрийн хөрөнгийн эх үүсвэр хоёрын харьцааг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Нийт хөрөнгөнд мөнгөн хөрөнгийн эзлэх хувь (*casht*): Энэ ойлголтод байгууллага төлөвлөж буй төрөл бүрийн төлбөр ба гэнэтийн шаардлагуудыг хангаж байхын тулд, өөрөөр хэлбэл, хөрвөх чадвараа өндөр байлгахын тулд гар дээрээ бэлэн мөнгө хэлбэрээр хадгалж буй хөрөнгө эсвэл түүнтэй адил хөрвөх чадвартай хөрөнгө болох түргэн борлогдох үнэт цаасыг хамруулж ойлгоно.

Капиталжилт буюу нийт хөрөнгөнд үндсэн хөрөнгийн эзлэх хувь (*capint*): Капитал гэж урт хугацаанд үйлдвэрлэлийн процесст ашиглагдаж, хүний хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өмчлөгч эзэндээ байнгын орлого оруулж байдаг үйлдвэрлэлийн хүчин зүйлийг хэлнэ. Капитал гэсэн ойлголтын цаана зөвхөн урт хугацааны эх үүсвэрийг авч үзэж болно.

Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (*cfot*): Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн өөрчлөлт нь бэлэн байгаа мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлж байгааг харуулдаг. Энэ урсгалын нэмэгдэх өөрчлөлт нь: Авлага цуглуулалт, богино хугацаат зээлийн өсөлт байдаг бол буурах эх үүсвэр нь болон богино хугацаат өр төлбөрийн бууралт, нөөцийн өсөлт зэрэг байдаг байна.

## Хүснэгт 2. Тодорхойлох статистик

Хувьсагч	Түүврийн тоо	Дундаж	Ст.хаз.	Хамгийн бага	Хамгийн их
<i>gaap_etr</i>	106,288	0.083	0.081	0.000	1.000
<i>size</i>	106,288	11.158	2.289	-0.356	23.317
<i>roa</i>	106,288	-0.637	147.043	-46,720.530	2,867.151
<i>lev</i>	106,288	0.056	0.508	-36.893	117.130
<i>casht</i>	106,288	0.206	0.278	-0.892	1.413
<i>capint</i>	106,288	0.365	0.329	-16.867	16.376
<i>cfot</i>	106,288	-0.042	11.137	-2,194.089	771.831

## Судалгааны үр дүн

Тодорхойлох статистикийн үр дүнг Хүснэгт 2-т харуулав. Онолын хувьд татварын үр ашигтай хувь хэмжээ гэдэг нь татвар төлөгчийн хувьд бодит хувь, өөрөөр хэлбэл одоогийн төлж буй татварын хэмжээг тодорхойлох хувь хэмжээ юм. Татварын үр ашигтай хувь хэмжээ 20 хувь болон түүнээс бага аж ахуйн нэгжүүдийг татварын үр ашигтай хувь хэмжээ “бага” гэж ангилдаг. 10 болон түүнээс бага хувьтай аж ахуйн нэгжүүдийн хувьд “Red Flag” буюу тухайн байгууллагын татварын тайлагнал, татвар төлөлттэй холбоотой шийдвэрлэх асуудал байна гэж үздэг. Харин тус хувь хэмжээ 40 хувь болон түүнээс дээш аж ахуйн нэгжүүдийг татварын үр ашигтай хувь хэмжээ “их” гэж ангилдаг (Dyregng, 2008; Цэцэгдэлгэр & Алтан-Эрдэнэ, 2021).

Dyregng (2008) нарын судлагааны үр дүнтэй харьцуулахад манай улсад тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын GAAP ETR үзүүлэлтийн дундаж нь 8% байгаа нь түүвэрт сонгогдсон аж ахуйн нэгжүүдийн хувьд татвараас зайлсхийх байдал өндөр байгааг харуулж байна.

Үнэлгээний үрдүнгийн найдвартай байдлыг хангах зорилгоор үл хамаарах хувьсагчдын коррелляцийн коэффициентийг тооцоолж, үр дүнг Хүснэгт 3-т харуулав. Хэрэв хоёр төрлийн хувьсагчийн утгууд нэг чигт өөрчлөгдөж байвал эерэг хамааралтай, эсрэг чигт өөрчлөгдөж байвал сөрөг хамааралтай гэж үздэг.

Дээрх тооцооллын үр дүнгээс харахад аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээ болон хөрөнгийн өгөөж зэрэг үзүүлэлтүүд татварын үр ашигтай хувь хэмжээнд

## Хүснэгт 3. Корреляцийн шинжилгээ

Хувьсагч	<i>gaap_etr</i>	<i>size</i>	<i>roa</i>	<i>lev</i>	<i>casht</i>	<i>capint</i>
<i>size</i>	0.0305 ***					
<i>roa</i>	0.0057 *	0.0191 ***				
<i>lev</i>	-0.0402 ***	0.0621 ***	-0.0006			
<i>casht</i>	0.0320 ***	-0.2461 ***	-0.0115 ***	-0.0309 ***		
<i>capint</i>	-0.0705 ***	0.0645 ***	0.0046	0.0298 ***	-0.3701 ***	
<i>cfot</i>	0.0130 ***	0.0371 ***	0.0522 ***	-0.0114 ***	-0.0148 ***	0.0098 ***

Тайлбар: \*\*\*, \*\*, \* нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг илтгэнэ.

зэрэг нөлөөтэй байгаа нь байгууллага томрох, хөрөнгийн өгөөж нэмэгдэх, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувийн жин ихсэх, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурдаг болохыг харуулж байна. Харин эсрэгээрээ санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна. Мөн бусад хяналтын хувьсагчдын хамаарлыг эндээс харж болхоор байна.

Тооцооллын үндсэн үр дүнг хүснэгт Хүснэгт 4-т харууллаа. Эндээс харахад бүх аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд тэдгээрийн хэмжээ хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувийн жин татварын үр ашигтай хувь хэмжээнд зэрэг нөлөө үзүүлж байгаа нь байгууллага томорч, үйл ажиллагаа нь сайжрахын хэрээр санхүүгийн чадавхи нэмэгдэж улмаар татвар төлөлт сайжирдаг жишгийг

баталж байгаа юм. Харин санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байгаа нь өр төлбөр нэмэгдэхэд үйл ажиллагаанаас олсон орлогоо хүүтэй зээлийн төлбөрт шилжүүлэх, нөгөөтэйгүүр орлогоо тоног төхөөрөмж, машин техник гэх мэт үндсэн хөрөнгөнд хувиргаж байгаа нь мөнгөн хөрөнгө багасахад нөлөөлж татвар төлөлтийг бууруулдаг үйл явцыг харуулж байна. Эдгээр үр дүн коррелляцийн шинжилгээний үр дүнтэй ижил байгаа боловч хөрөнгийн өгөөж болон үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ зэрэг хувьсагчдын хувьд хамаарал нь тодорхойгүй гэж гарсан байна.

Бичил аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд бүх аж ахуйн нэгж, байгууллагаас ялгаатай нь үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч байна.

Хүснэгт 4. Судалгааны үндсэн үр дүн

Хувьсагч	Бүх ААН	Бичил ААН	Бичил бус ААН	Нийслэлийн ААН	Орон нутгийн ААН
<i>size</i>	0.0046 ***	0.0037 ***	0.0059 ***	0.0061 ***	0.0012 **
<i>roa</i>	0.0000	0.0000	0.0000	0.0000	0.0001 ***
<i>lev</i>	-0.0028 ***	-0.0022 ***	-0.0127 ***	-0.0009	-0.0131 ***
<i>casht</i>	0.0111 ***	0.0140 ***	0.0032	0.0122 ***	0.0067 ***
<i>capint</i>	-0.0127 ***	-0.0112 ***	-0.0160 ***	-0.0153 ***	-0.0094 ***
<i>cfot</i>	0.0000	0.0000 *	0.0000	0.0000	-0.0001 *
Сул гишүүн	0.0345 ***	0.0461 ***	0.0116	0.0104 *	0.0802 ***
Түүврийн тоо	106,286	72,609	33,677	62,503	43,783
ААН-ийн тоо	15,184	10,373	4,811	8,929	6,255
F статистик	64.20 (0.0000)	56.94 (0.0000)	19.10 (0.0000)	54.44 (0.0000)	26.59 (0.0000)
R <sup>2</sup>	0.0048	0.0028	0.0141	0.0178	0.0057
Hausman тест	172.47 (0.0000)	212.75 (0.0000)	31.25 (0.0000)	93.61 (0.0000)	38.30 (0.0000)

Тайлбар: \*\*\*, \*\*, \* нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг илтгэнэ.

Бичил бус аж ахуйн нэгжүүдийн хувьд тэдгээрийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нь буурч, санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нь нэмэгдэж байгаа үр дүн гарсан.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд тэдгээрийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь татварын үр ашигтай хувь хэмжээний хооронд эерэг хамааралтай, харин капиталжилт болон татварын үр ашигтай хувь хэмжээний хооронд сөрөг хамааралтай байна.

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд байгууллагын хэмжээ, хөрөнгийн өгөөж, мөнгөн хөрөнгийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувийн жин нэмэгдэх

тусам татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг болон үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байгааг харж болохоор байна.

F статистикаар үнэлгээний үр дүн бодитой гарсан эсэхийг шалгадаг бөгөөд дээрх үр дүнг хүлээн зөвшөөрч болохыг харууллаа. Тэгшитгэлийн илэрхийлэх хувь буюу R<sup>2</sup> нь тухайн загварын тохирох байдлын талаар тодорхой мэдээлэл өгөх статистик үзүүлэлт бөгөөд бидний тэгшитгэлийн 0.48 хувийг тайлбарлаж байна. Хаусмэн тест нь тухайн тэгшитгэлийг тогтмол нөлөөний аргаар бодох уу?, санамсаргүй нөлөөний аргаар бодох уу? гэдгийг шалгадаг тест юм. Дээрх үнэлгээний дүнгээс харахад P-value 0.0000 байгаа нь тогтмол нөлөөний аргаар бодохыг зааж байгаа бөгөөд Хүснэгт 4-ийн үр дүн тогтмол нөлөөний аргаар үнэлсэн тооцооллын үр дүн болно.

Хүснэгт 5. Салбарын нөлөөллийн үр дүн (A-G)

Хувьсагч	A	B	C	D	E	F	G
size	0.0024	0.0091	0.0023 *	0.0135 **	0.0061	0.0071 ***	0.0046 ***
roa	0.0062 ***	0.0004	0.0000	0.0076	0.0380 **	0.0000	0.0001 **
lev	0.0103	-0.0129	-0.0001	-0.0253	0.0194	-0.0107	-0.0103 ***
casht	0.0050	-0.0409	0.0089	0.0822 **	0.0780 **	0.0127 **	0.0062 ***
capint	-0.0177 **	-0.0505 *	-0.0119 **	-0.0016	-0.0388	-0.0149 **	-0.0141 ***
cfot	-0.0060 ***	0.0102	0.0000	-0.0132 **	-0.0240	0.0002	0.0000
Сул гишүүн	0.0493 **	-0.0117	0.0564 ***	-0.1097	-0.0131	0.0044	0.0421 ***
Түүврийн тоо	3,773	868	8,561	707	294	8,638	38,575
ААН-ийн тоо	539	124	1,223	101	42	1,234	5,511
F статистик	4.3622	1.1854	2.4646	2.7896	3.1008	7.8235	26.4551
R <sup>2</sup>	0.0027	0.0387	0.0026	0.0012	0.0481	0.0142	0.0040

Тайлбар: \*\*\*, \*\*, \* нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг илтгэнэ.

A - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур; B - Уул уурхай, олборлолт;

C - Боловсруулах үйлдвэрлэл; D - Цахилгаан, хий, уур, агааржуулалт;

E - Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа;

F - Барилга; G - Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ

Бид аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдалд салбарын нөлөө байгаа эсэхийг харах зорилгоор салбар хоорондын харьцуулсан үнэлгээ хийснийг Хүснэгт 5, 6, 7-д тус тус харууллаа. Салбарын ангиллын код нь Үндэсний статистикийн хорооноос 2019 онд шинэчлэн баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын код болно.

А буюу Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт хөрөнгийн өгөөж нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, капиталжилт болон үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

В буюу Уул уурхай, олборлолтын салбарт капиталжилт буурахад татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

С буюу Боловсруулах үйлдвэрлэлийн

салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

Д буюу Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

Е буюу Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт хөрөнгийн өгөөж, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурдаг.

Ф буюу Барилгын салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд

Хүснэгт 6. Салбарын нөлөөллийн үр дүн (Н-М)

Хувьсагч	Н	І	Ј	К	Л	М
<i>size</i>	0.0048 *	0.0028 *	0.0080 ***	0.0093 **	0.0008	0.0024
<i>roa</i>	0.0003	0.0000	0.0000	0.0040	0.0001	0.0001
<i>lev</i>	0.0001	0.0001	-0.0191 ***	0.0167	-0.0210	-0.0125 ***
<i>casht</i>	0.0004	0.0144 **	0.0272 ***	0.0020	0.0278	0.0239 ***
<i>capint</i>	-0.0214 *	-0.0175 ***	-0.0125	-0.0210	-0.0241	0.0001
<i>cfot</i>	-0.0001	0.0000	0.0003	-0.0004	0.0024	0.0000
Сул гишүүн	0.0327	0.0538 ***	-0.0128	-0.0021	0.0769	0.0544 ***
Түүврийн тоо	1,960	4,536	2,226	1,344	1,799	7,091
ААН-ийн тоо	280	648	318	192	257	1,013
F статистик	1.6132	4.5580	6.5238	1.5860	2.2372	13.2491
R <sup>2</sup>	0.0090	0.0082	0.0604	0.0175	0.018	0.0081

Тайлбар: \*\*\*, \*\*, \* нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг илтгэнэ.

Н - Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа; І - Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ;

Ј - Мэдээлэл, холбоо; К - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа;

Л - Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа; М - Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа



эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгддэг.

G буюу Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, хөрөнгийн өгөөж, мөнгөн хөрөнгийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна. Энэ салбарын хувьд хамгийн олон хүчин зүйл татвараас зайлсхийх байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа нь нийт түүврийн хамгийн их буюу 5,511 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн мэдээлэл ашиглагдсантай холбоотой гэж үзсэн.

H буюу Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх

байдал буурч, капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

I буюу Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

J буюу Мэдээлэл, холбооны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

K буюу Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурдаг байна.

Хүснэгт 7. Салбарын нөлөөллийн үр дүн (N-S)

Хувьсагч	N	O	P	Q	R	S
size	0.0042 **	0.4773 **	0.0047	0.0048 ***	0.0048	0.0060 **
roa	0.0028 ***	1.0018	0.0070 **	0.0005	-0.0016	0.0055 ***
lev	-0.0306 ***	-12.8292 *	0.0069	-0.0065	-0.0172	-0.0188 *
casht	0.0201 **	-0.8262	0.0351 **	0.0235 ***	0.0329	-0.0003
capint	-0.0007	6.3857 **	-0.0011	-0.0056	0.0063	-0.0038
cfot	-0.0028 ***	0.4276	-0.0069 **	0.0006	-0.0044	-0.0004
Сул гишүүн	0.0281	-8.0640 **	0.0138	0.0244	0.0013	-0.0118
Түүврийн тоо	3,381	14	1,575	5,635	161	1,561
ААН-ийн тоо	483	2	225	805	23	223
F статистик	6.1140	2.2811	3.4056	6.0499	1.5091	4.1375
R <sup>2</sup>	0.0308	0.7086	0.0013	0.0248	0.0033	0.0138

Тайлбар: \*\*\*, \*\*, \* нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг илтгэнэ.

N - Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа; I - Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ;

J - Мэдээлэл, холбоо; K - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа;

L - Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа; M - Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа

М буюу Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт мөнгөн хөрөнгө нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгддэг.

Н буюу Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, хөрөнгийн өгөөж, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг болон үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

О буюу Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, капиталжилт нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.

Р буюу Боловсролын салбарт хөрөнгийн өгөөж, мөнгөн хөрөнгө нэмэгдэхэд

татвараас зайлсхийх байдал буурч, цэвэр мөнгөн гүйлгээ нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байна.


Q буюу Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч байна.

S буюу Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт аж ахуйн нэгжийн хэмжээ, хөрөнгийн өгөөж нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурч, санхүүгийн хөшүүрэг нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал нэмэгддэг байна.

L буюу Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны болон R буюу Урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдалд статистикийн хувьд нөлөөлж буй ямар нэг хүчин зүйл байхгүй.

Дээрх салбаруудын үр дүнг нэгтгэн График 1-т харууллаа. Нийт 19 салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын 17 салбарын хувьд

Хүснэгт 7. Салбарын нөлөөллийн үр дүн (N-S)



тэдгээрийн татвараас зайлсхийх байдалд дээрх хүчин зүйлүүд эерэг болон сөрөг нөлөөтэй, харин 2 салбарын хувьд ямар нэг нөлөөгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл хамгийн олон салбарт буюу 12 салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын татварын үр ашигтай хувь хэмжээнд аж ахуйн нэгжийн хэмжээ, 10 салбарт мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь эерэгээр нөлөөлдөг буюу дээрх үзүүлэлтүүд нэмэгдэхэд татвараас зайлсхийх байдал буурдаг байна.

#### Дүгнэлт

Манай улсын хувьд татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх болон татвараас зайлсхийх нь гэмт хэрэг болох тал дээр хийгдсэн судалгааны ажлууд байгаа боловч татвараас зайлсхийх байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар судалсан ажил хараахан хийгдээгүй байна. Иймээс бид энэхүү судалгааны ажлаараа татвараас зайлсхийж буй байдалд аж ахуйн нэгжийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг тооцохыг зорьсон. Ингэхдээ аж ахуйн нэгжийн хэмжээ, хөрөнгийн өгөөж, санхүүгийн хөшүүрэг, мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь, капиталжилт, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ зэрэг хүчин зүйлүүдийг ашиглан тэдгээрийн татвараас зайлсхийх байдалд нөлөөлөх нөлөөллийг тооцсон. Мөн салбар хоорондын харьцуулалт хийх зорилгоор салбар тус бүрт дээрх хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байгааг тооцож, үр дүнг нэгтгэсэн. Судалгааны түүвэрт Сангийн яамны цахим тайлангийн системд бүртгэлтэй 2013-2019 оны

хооронд үйл ажиллагаа явуулж байсан 77,515 аж ахуйн нэгжүүдээс загварын шалгуурын дагуу 15,184 аж ахуйн нэгжийн 106,288 санхүүгийн тайлангийн мэдээлэл сонгогдож үнэлгээнд ашиглагдсан. Тодорхойлох статистикийн үр дүнд GAAP ETR буюу татвараас зайлсхийх байдлын дундаж үзүүлэлт 8% байна. Коррелляцийн шинжилгээний болон үндсэн үр дүнгээс харахад бүх аж ахуйн нэгж, байгууллагын хувьд аж ахуйн нэгжийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал буурч байгаа нь аж ахуйн нэгж өргөжин томорч, үйл ажиллагаа нь сайжрахын хэрээр санхүүгийн чадавхи нэмэгдэж улмаар татвар төлөлт сайжирдаг. Харин санхүүгийн хөшүүрэг болон капиталжилт нэмэгдэх тусам татвараас зайлсхийх байдал нэмэгдэж байгаа нь өр төлбөр нэмэгдэхэд үйл ажиллагаанаас олсон орлогоо хүүтэй зээлийн төлбөрт шилжүүлэх, олсон орлогоо тоног төхөөрөмж, машин техник гэх мэт үндсэн хөрөнгөнд хувиргаж байгаа нь мөнгөн хөрөнгө багасахад нөлөөлж татвар төлөлтийг бууруулж болох үйл явцыг харуулж байна. Салбар хоорондын харьцуулсан судалгааны үр дүнд нийт 19 салбараас 17 салбар дах аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдалд дээрх хүчин зүйлүүд эерэг болон сөрөг нөлөөтэй бол 2 салбарын хувьд ямар нэг нөлөөлөл ажиглагдаагүй. Нэгтгэн дүгнэвэл аж ахуйн нэгжийн хэмжээ, байршил, салбарын онцлогоос үл хамаарч тэдгээрийн татвараас зайлсхийж буй байдалд аж ахуйн нэгжийн хэмжээ болон мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь хамгийн их нөлөөтэй байна.

## Ашигласан материал

- Chen, K. P. & Chu, C. (2005). Internal Controls vs. External Manipulation: A Model of Corporate Income Tax Evasion. *RAND Journal of Economics*, 36, 151-164.
- Cowell, F. A. (1992). Tax Evasion and Inequity. *Journal of Economic Psychology*, 13(4), 521–543.
- Crocker, K. & Slemrod, J. (2005). Corporate Tax Evasion with Agency Costs. *Journal of Public Economics*, 89, 1593-1610.
- Desai, M. A., & Dharmapala, D. (2006). Corporate Tax Avoidance and High-Powered Incentives. *Journal of Financial Economics*, 79, 145-179.
- Devos, K., McGee, W. R., & Benk, S. (2019). Attitudes toward Tax Evasion in Turkey and Australia: A Comparative Study, Social Sciences. *The Journal of Accounting and Finance* 23(1), 1-13.
- Dyregang, S., Hanlon, M., & Maydew, E. L. (2008). Long-Run Corporate Tax Avoidance. *The Accounting Review*, 83(1), 61-82.
- Eddy, E. P. S., Angela, A., & Erna (2020). The Impact Analysis of Return on Assets, Leverage and Firm Size to Tax Avoidance. *Jurnal Akuntansi*, 12(2), 256-264.
- Kurniasih, T. & Sari, M. M. R. (2013). The Effect of Return on Assets, Leverage, Corporate Governance, Company Size and Fiscal Loss Compensation on Tax Avoidance. *Economic Studies Bulletin*, 18, 58-66.
- Hormati (2009). Company Characteristics on the Quality of Corporate Governance Implementation. *Journal of Finance and Banking*, 288-298.
- Золбоо, Г. (2018). Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй шалтгаан, хүчин зүйлд хийсэн дүн шинжилгээ.
- Цэцэгдэлгэр, Э. & Алтан-Эрдэнэ, Б. (2021). Аж ахуйн нэгж байгууллагуудын татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх нь. *Journal of Accounting Theory and Practice*, 5(1), 81-91.